

*Соёлоор харилцах Монголын нийгэмлэг (МОКС) үүсч хөгжсөний 60 жилийн ойд зориулсан “Монгол ба Орос: сайн хөршийн найрсаг харилцаа” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Монгол Улсын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, ОХУ-ын ШУА-ийн Буриадын эрдэм шинжилгээний төв, Найрамдлын нийгэмлэгүүдийн Монголын эвлэл, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн зэрэг байгууллагууд 2007 оны 05 сарын 21-нд Улаанбаатар хотноо зохион байгуулав.*

## **ШУА-ИЙН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ, АКАДЕМИЧ Б.ЭНХТҮВШИНГИЙН ХУРЛЫГ НЭЭЖ ХЭЛСЭН ҮГ**

“Монгол ба Орос: сайн хөршийн найрсаг харилцаа” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулахаар та бүгдийг урьсан, бид бүгдийн урилгыг хүлээн авч энэ зааланд хүрэлцэн ирсэн хүмүүст талархал илэрхийлж байна. Манай хуралд Оросын Холбооны Улс, Монгол Улсын баатар, сансрын нисгэгч Горбатко тэргүүтэй ОХУ-ын эрдэмтэд судлаачид, нийгэмлэгийн идэвхтэнүүд оролцож байгааг энд та бүхэнд мэдэгдэхэд таатай байна. Манай хурлын ажиллагаанд Монгол Улсын Их Хурлын дарга Нямдорж гуай өөрийн биеэр оролцож үг хэлэх гэж байгаад манай хурлын агуулга улам баян, ач холбогдолтой болж байгааг онцлон тэмдэглэж Монгол Улсын Их Хурлын даргад хуралд оролцогчдын нэрийн өмнөөс баярлаж талархаж байгаагаа илэрхийлж байна. Хурлын хөтөлбөрийг та бүхэнд тараасан байгаа, энэ хөтөлбөрийн дагуу өнөөдрийн хурлыг зохион байгуулж явуулах юм. Хурал үндсэн илтгэгч нар 15 минут илтгэл тавина, Монгол-Оросын харилцаа, найрамдлын нийгэмлэг үүсч байсан үүргийн талаар Монгол Улсын Их Хурлын гишүүн, найрамдлын нийгэмлэгийн Монголын эвлэлийн тэргүүн Монгол, Зөвлөлт Холбоот Улсын баатар Ж.Гүррагчаа илтгэл тавина, “Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбар дахь Монгол Улс, Оросын Холбооны Улсын хамтын ажиллагаа” гэсэн үндсэн илтгэлийг БСШУЯ-ны дэд сайд, энэ хурлыг зохион байгуулах ажлын хэсгийн ахлагч профессор С.Төмөр-Очир гуай илтгэх юм. Хуралд байгууллага, манай Ерөнхий сайдаас илгээлт ирсэн байгаа, энэ илгээлтийг Ерөнхий сайдын зөвлөх Батбаяр болон бусад илгээлтийг хүмүүс уншиж мэндчилгээ дэвшүүлэх юм. Хурлын ажиллагаа нээснийг мэдэгдэж байна.